

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

№ 19 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/36

Сүмбэр сум

Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах хяналт шалгалтын ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Говьсүмбэр аймгийн Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
2. Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахыг нийгмийн ажилтан /Б.Шархүү/-д даалгасугай.
3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 37 000 /гучин долоон мянга/ төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал

Г 421190060